



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Э.БАТШУГАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2026.06.08 № 32

Эрүүл мэндийн байгууллагын сонгон
шалгаруулалтын талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн санал, хүсэлтийг үндэслэн дараах асуултыг тавьж байна.

1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг баталсан бөгөөд энэхүү журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Сонгон шалгаруулалтыг гурван жилд нэг удаа нэгдсэн журмаар зохион байгуулна” гэж заасны дагуу нэгдсэн сонгон шалгаруулалтыг 2022 оны 8 дугаар сард зохион байгуулсан байна. Дараагийн нэгдсэн сонгон шалгаруулалтын хугацаа 2025 оны 8 дугаар сард байсан ч өнөөдрийг хүртэл зохион байгуулаагүй шалтгаан, дахин зохион байгуулах хугацааны талаарх мэдээлэл;

2. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4, 14 дүгээр зүйлийн 14.9.11 дэх заалтад заасан сонгон шалгаруулалт нь иргэн, даатгуулагчийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг хангахад ямар үр дүн үзүүлж байгаа талаарх мэдээллийг дараах хүрээнд ирүүлэх:

а/2022 оны нэгдсэн сонгон шалгаруулалтад оролцсон болон шалгарсан эрүүл мэндийн байгууллагуудыг өмчийн хэлбэрээр нь ангилсан тоон мэдээлэл болон сонгон шалгаруулалтад тэнцээгүй гол үндэслэл, шалтгаан;

б/Иргэн, даатгуулагч өмчийн хэлбэр үл харгалзан тусламж үйлчилгээ авах эмнэлгээ сонгох эрх бодит байдал дээр хэрхэн хангагдаж байгаа талаарх үнэлгээ, статистик мэдээлэл;

в/Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд сонгон шалгаруулалтад тэгш эрхтэй оролцох, шалгаруулах нөхцөлөөр тэгш хангагдаж байгаа эсэх талаарх мэдээлэл.

2026000032

3.Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний гэрээ байгуулах байгууллагыг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлал, онооны системийн ил тод байдлыг хэрхэн хангаж байгаа, сонгон шалгаруулалтын шийдвэрт гомдол гаргасан байгууллагын тоо, шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Д.ГАНМАА

2020000032